



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/73

Модот

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нотариатын 2025 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн 0020 тоот гэрээг судлан үзээд, Цэгмид овогтой Рэнцэндорж (НБ67121579)-ийн эзэмшиж буй 4 дүгээр баг Баянмод, Бяцхан булгийн адагт, 2321000781 нэгж талбарын дугаартай Фермерийн аж ахуйн зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Хүрлээ овогтой Мөнхзагас (УГ68021108)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар эзэмшил, ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигч Хүрлээ овогтой Мөнхзагас-д даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Я.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын засаг даргын 2016 оны 05-р сарын 16 ны өдрийн А/56 тоот захирамжын иргэн Хүрлээ овогтой Мөнхзагас-д холбогдох хэсэг эзэмшлийн 000710332 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ



